



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 8 өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

Шуурхай бүлгийг татан буулгах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1.1}, 27^{1.1.4} дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаан бурхан өвчний дэгдэлтийн эрсдэлийн үнэлгээгээр идэвхжилийн зэрэг "0" буюу ногоон түвшинд үнэлэгдсэн тул Улсын онцгой комиссын даргын тушаалаар байгуулагдсан Шуурхай бүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөр тасалбар болгож татан буулгасугай.

2. Шуурхай бүлгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан мэдээллийг Улсын онцгой комисст, салбар хоорондын мэдээллийн систем хөгжүүлэх ажлын даалгаварыг 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн дотор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яаманд тус тус хүлээлгэж өгөхийг Шуурхай бүлгийн ахлагч, Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын хэлтсийн дарга, хурандаа Б.Мягмардоржид даалгасугай.

3. Шуурхай бүлгийн боловсруулсан салбар хоорондын мэдээллийн систем хөгжүүлэх ажлын даалгаварыг цаашид хариуцаж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам (Ц.Баатархүү), Эрүүл мэндийн яам (Т.Мөнхсайхан)-нд тус тус үүрэг болгосугай.

4. Шуурхай бүлэг татан буугдсантай холбогдуулан Улсын онцгой комиссын даргын "Шуурхай бүлэг байгуулах тухай" 2024 оны 9 дүгээр 2-ны өдрийн 7 дугаар тушаалыг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

